

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын
2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн
08/25.3 дугаар албан бичгийн хавсралт



НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

ХУУЛЬ, ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 02 Улаанбаатар хот

Д/д	Шийдвэрийн нэр, огноо	Зүйл заалтын дугаар	Зүйл заалтын агуулга	Хэрэгжилтийн тайлан	Хэрэг-жилтийн хувь	Хэрэгжээ-гүй шалтгаан	Хяналтаас хасах үндэслэл
1	2	3	4	5	6	7	8
1. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ							
1.	Биеийн тамир, спортын тухай хууль 2024 оны 06 дугаар сарын 05	12 дугаар зүйлийн 12.1	12.1.Аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн нутаг дэвсгэртээ биеийн тамир, спортын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:	Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлснээр Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 02/249, 02/250 дугаар албан тоотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2 зорилт 6 зорилт 47 ажил, арга хэмжээтэйгээр баталж 2025 оны жилийн эцсийн байдлаар гүйцэтгэлийн дундаж 99,36 хувьтай хэрэгжсэн байна.	100%	-	-
2.		13 дугаар зүйлийн 13.1	13.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:	Биеийн тамир, спортын тухай хуулийг 2025 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 14 ажил, арга хэмжээтэйгээр баталж жилийн эцсийн байдлаар хэрэгжилт 100% хувьтай байна.	100%	-	-
3.		23 дугаар зүйлийн 23.5	23.5.Аймаг, дүүргийн Засаг дарга спортын 10-	Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор өндөр зэрэгтэй	100%		

		аас доошгүй төрлөөр өсвөр үеийн шигшээ багийг байгуулан, орон нутаг дахь спортын холбоотой хамтран сонгон шалгаруулж, орон нутгийн төсвөөс үйл ажиллагааг санхүүжүүлнэ.	тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэх, дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж спортын 30 төрөлд 124 багт 124 дасгалжуулагчтай 4001 тамирчдыг бэлтгэл сургуулллтад хамруулж байна.			
4.	13 дугаар зүйлийн 13.1.5	13.1.5.сум, дүүрэг, хороонд орон тооны биеийн тамирын арга зүйч ажиллуулах.	Өсвөрийн шигшээ багийн тамирчид 2025 оны жилийн эцсийн байдлаар 382 удаагийн тив, дэлхий, олон улс, улс, нийслэл, нэрэмжит тэмцээнд оролцож 2067 медаль авсан амжилт үзүүлсэн. Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг дэмжиж улс, Нийслэл, ивээн тэтгэгч байгууллагууд болон бусад төсвөөс нийт 573,254,500 төгрөгийг зарцуулсан байна. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх оюутны шигшээ багийг спортын 8 төрлөөр байгуулах журмыг Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1626 дугаар захирамжаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Оюутны шигшээ багт шаардагдах төсвийг Нийслэлийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгаж, нийслэлийн 2026 оны төсөвт 1,165.000.0(нэг тэр бүм нэг зуун жаран таван сая) төгрөгийг батлуулахаар саналыг хургуулэн ажилласан. Дүүргийн хороодод орон тооны арга зүйч ажиллуулах тухай саналыг холбогдох дээд байгууллагуудад хургуулж, "Биеийн тамир, спортын тухай хууль"-д заалт болгож тусгуулсан. Нийслэлийн хэмжээнд хэрэгжилтийг ханган ажиллах ажлын хүрээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар орон тооны арга зүйч ажиллуулахад шаардлагатай орон тоо, цалин хөлс, сургалтын төсвийн тооцооллыг боловсруулж Биеийн тамир, спортын улсын хороонд 2026 оны улсын төсөвт туслуулахаар санал боловруулан 2025 оны 06 дугаар сард хургуулсан. Мөн тус заалтыг Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Нийслэлийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд хэрэгжүүлэхээр тусгуулсан.	90%	2025 онд төсөвд суугдаагуй.	

2.ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1.	Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх тухай 2010 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 53 дугаар зарлиг	1 дүгээр зүйл	1.Монгол Улсын хүн амын орчин үеийн эрүүл амьдралын хэв маяг, зан үйлд сургах, аливаа саад, бэрхшээлийг даван туулах бие, сэтгэлийн тэсвэр хатуужилтай шинэ үеийг бий болгох зорилгоор “Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилт”-ыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар жил бүрийн дөрөвдүгээр сард явуулж, үнэлэлт, дүгнэлтийг үндэслэн шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг;	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигийн дагуу бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилтыг Нийслэл, дүүргийн хэмжээнд зохион байгуулж 2025 оны жилийн эцсийн байдлаар 606 байгууллагын 85,122 иргэн хамрагдсан байна. Сорилд хамрагдсан хүмүүсийн: 26 % нь- А, 28 % нь- В, 23 % нь- С, 15 % нь- D, 8 % нь- F үнэлгээ авсан ба нийт 77% нь А,В,С үнэлгээ байна. Сорилд хамрагдсан иргэдийн мэдээлэл, чанарын үзүүлэлтийг www.sport.sport.gov.mn сайтад шивж оруулсан.	100%		
2.	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2014 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 27 дугаар зарлиг	4 дүгээр зүйл	4.Өвлийн спортын барилга байгууламжийн цогцолборт түшиглэн уралдаан, тэмцээн зохион байгуулах, Монгол Улсын тамирчид гадаад улсын баг, тамирчидтай бэлтгэл хийх, хамтран ажиллахыг хөхиүлэн дэмжихийг;	Өвлийн улиралд иргэдийн бие бялдрыг чийрэгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр 20 удаагийн биеийн тамир, спортын арга хэмжээ, 27 байршилд мөсөн гулгуурын талбай, цанын баазыг байгуулж, биеийн тамир, спортын үйлчилгээг нийт 447,595 иргэдэд хүргэж ажилласан. Үүнд: -Нийслэлийн 9 дүүрэгт нийтийг хамарсан 11 арга хэмжээ зохион байгуулж 26,709 иргэнийг хамруулсан. -Өвлийн спортын төрлөөр Улаанбаатар хотын аварга шалгаруулах уралдаан, тэмцээнийг 7 удаа зохион байгуулж 693 тамирчин оролцсон. -Дүүргүүдийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багт өвлийн спортын 3 төрөл (хоккей, тэшүүр, шорттрейк)-ийн төрлөөр 95 хүүхэд, багачууд секц, дугуйланд хамрагдаж байна. -Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт байрлах битүү дээвэртэй мөсөн гулгуурын талбайд 2025 оны 01	100%		

			дүгээр сарын 02-ноос 11 дүгээр сарын 27-ны хооронд 132,098 иргэн үйлчлүүлсэн байна. -Сүхбаатар, Баянзүрх, Багануур дүүрэгт Хандайгт, Скай ресорт, Галуут тур, Улаанбаатар цанын баазуудад 172,000 иргэн үйлчлүүлсэн байна. -Орон сууц, гэр хорооллын 22 байршилд мөсөн тулгуурын талбай байгуулагдаж 116,000 иргэдэд үйлчилгээ үзүүлсэн байна.				
	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2015 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 144 дүгээр зарлиг	1 дүгээр зүйл	1.Үндэсний болон хөлбөмбөг, хоккейн спортыг хөгжүүлэх орчин үеийн шаардлага, стандартыг хангасан барилга байгууламжийн цогцолборыг нийслэл Улаанбаатар хот болон боломжтой бусад суурин газарт барилдах, газрын асуудлыг шийдвэрлэх, дотоод, гадаадын зохих хөрөнгө оруулалтыг төр, хувийн хэвшлийн туншлал, хамтын ажиллагаанд тулгуурлан шийдвэрлэх;	Хөлбөмбөгийн спортыг хөгжүүлэх зорилгоор нийслэлийн ЕБС-иудын биеийн тамир, спортын гадна талбайн судалгаанд үндэслэн 2021 онд ЧД-н 24, 2022 онд СБД-н 2, ХУД-н 34, 52, 2023 онд ЧД-н 57, СХД-н 67, ХУД-75 дугаар сургуулийн гадна талбайг дүүргийн ЗДТГ-н санхүүжилтээр шийдүүлж суурийн ажлыг гүйцэтгэж, Монголын Хөлбөмбөгийн холбоотой хамтран ОУ-ын стандарт шаардлага хангасан хөлбөмбөгийн талбайг тохижуулсан. 2024 онд Баянгол дүүргийн Оюуны ундраа цогцолбор сургуулийн гадна талбайг үерийн далан байгуулах ажлыг хийсний дараа тохижуулахаар хүлээгдэж байна. Хоккейн спортыг хөгжүүлэх орчин үеийн шаардлага, стандартыг хангасан барилга байгууламж барих зорилгоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Биеийн тамир, спортын Улсын хорооны захиалгаар хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Хан-Уул дүүргийн 8-р хороонд орчин үеийн стандарт шаардлагыг хангасан, өвлийн спортын битүү дээвэртэй, 7800м2 ашигтай талбайтай, 2500 хүний суудалтай “Степпе Арена” мөсөн өргөө, Чингэлтэй дүүргийн спорт цогцолборын “С” блок буюу хоккейн талбай ашиглалтад орж жилийн 4 улиралд үйл ажиллагаа явуулж байна. Мөн Сонгинохайрхан дүүргийн 20-р хороонд баригдаж байгаа өвлийн ордон ажлын гүйцэтгэл 50 хувьтай хэрэгжиж байна.	100%		
4.	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022 оны 04 дүгээр сарын	1 дүгээр зүйлийн 1.8 дахь хэсэг	1.8.Иргэд, залуучуудын цагийг зөв боловсон өнгөрөөх, биеийн тамир, спортоор хичээллэх	2025 онд Сонгинохайрхан дүүргийн 3-р хороонд хөл бөмбөгийн хиймэл зүлэг бүхий спортын иж бүрэн талбай шинээр байгуулагдсан бол бусад дүүргүүдэд 58 байршилд спортын зориулалтын	100%		

05-ны өдрийн 43 дугаар зарлиг	орчин нөхцөлийг бүрдүүлэхэд зохион байгуулалт, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагуудыг дэмжин хамтран ажиллах;	талбайг хувийн аж ахуй нэгж байгууллагуудаас шинэчлэн тохижуулж нийт 234 талбай болсон. Ур дүн: Биеийн тамир, спортын зориулалтын талбай 2019 оны суурь үзүүлэлт 101 байсан бол 2025 оны байдлаар 133-аар нэмэгдэж 234 болсон.		
-------------------------------	---	---	--	--

Хэсгийн дундаж 100 хувь

3.МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1.	Журам батлах тухай 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 183 дугаар тогтоол	2 дугаар зүйл	Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах, шаардлагатай хөрөнгө оруулалтыг бодлогоор дэмжин улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусган, шийдвэрлэж ажиллахыг;	Монгол Улсын Засгийн газрын 183 дугаар тогтоолын дагуу Монголын хүүхдийн спортын өвөл, зуны VIII наадмыг 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөс 06 дугаар сарын 06-ны өдрийг хүртэл зохион байгуулж, нийт 40 спортын төрлөөр 6666 тамирчид оролцсон. Монголын хүүхдийн спортын өвлийн наадамд 1-р байранд Баянзүрх дүүрэг, Зуны спортын наадамд: 1-р байранд Хан-Уул дүүрэг, 2-р байранд Сүхбаатар дүүрэг, 3-р байранд Чингэлтэй дүүргийн баг тамирчид тус тус эзэлсэн байна.	100%		
2.	Журам батлах тухай 2019 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 204 дүгээр тогтоол	2 дугаар зүйл	2."Түүхэн үйл явдал, тэмдэглэлт өдөр"-ийн жагсаалтыг 1 дүгээр хавсралт, тэмдэглэн өнгөрүүлэх журмыг 2 дугаар хавсралтаар баталж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг;	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг — Биеийн тамир, спортын улсын хорооноос 2025 оны 6 дугаар сарын 27-ны өдөр "Тамирчдын баар" арга хэмжээг Д.Сүхбаатарын талбайд зохион байгууллаа. Арга хэмжээнд нийт 100 Нийслэл, дүүргийн Биеийн тамир спортын газар, хороодын дарга, мэргэжилтнүүд, дасгалжуулагч, тамирчин, ахмад зүтгэлтэн нар оролцлоо.	100%		
3.	Төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх тухай 2020 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн	3 дугаар зүйл	3. Төрийн албан хаагчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, албан тушаалын ангилал, шатлал, зэрэглэл болон цалин хөлс тооцоолоход шаардагдах бусад мэдээлэлд өөрчлөлт	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 84, 238 дугаар тогтоолоор албан хаагчдын цалин хөлс, албан тушаалын ангилал, шатлал, зэрэглэл болон цалин хөлс тооцоолоход шаардагдах өөрчлөлтүүдийг 2 удаа давхардсан тоогоор 24 албан хаагчийн мэдээллийг төрийн албаны зөвлөлийн "Хүний нөөцийн удирдлагын систем"-д шинэчилж оруулсан. Мөн байгууллагын 16 албан	100%		

163 тогтоол	дугаар	орсон тухай бүрт өөрчлөлтийг хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системд үнэн зөв байдлаар оруулж, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж ажиллахыг;	хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг төрийн албаны зөвлөлийн "Хүний нөөцийн удирдлагын систем"-д оруулж баталгаажуулсан.			
4.	1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалт	1.1.харьяа байгууллага болон салбар, нэгжид сахилга, дэг журмыг сахиулах тодорхой арга хэмжээ авч, төрийн албаны хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг зөрчсөн албан хаагчид хариуцлага тооцож тухай бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байх;	Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын Ёс зүйн дэд хороог 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр хамт олны хурлаар хэлэлцэн санал хурааж 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан байгууллагын даргын 2025 оны А/13 тушаалаар батлуулж, 2025 оны Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөөг байгууллагын даргаар батлуулан хагас, бүтэн жилээр хэрэгжилтийг тайлагнан ажиллахаар төлөвлөсөн. 2025 оны жилийн эцсийн байдлаар Ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй бөгөөд иргэд, аж, ахуйн нэгж байгууллагаас албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээлэл ирээгүй байна.	100%		
5.	1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт	1.3.төрийн албан хаагчдын ажлын байрны шинжилгээ хийж, шинжилгээний дүнд тулгуурлан байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах;	Энэ дагуу 2022 оны А/20 дугаар тушаалаар төрийн захиргааны 13, төрийн үйлчилгээний 2 нийт 15 албан тушаалын тодорхойлолтыг баталж албан хаагчдыг байршуулан тухайн албан тушаалын тодорхойлолтын дагуу ажиллаж байна. Байгууллагын бүтэц орон тоо, цалингийн хэмжээ, нэмэгдлийг 2025 оны А/01 дүгээр тушаалаар шинэчлэн тогтоож хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%		

6.	Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 258 дугаар тогтоол	1 дүгээр зүйлийн 1.4 дэх заалт	1.4. төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллага болон төрийн холбогдох байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилох замаар төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх;	Байгууллагын хэмжээнд дэс түшмэлийн албан тушаалын 5 сул орон тоог нөхөн бүрдүүлэхээр нийтэд нээлттэй зарлаж, сул орон тооны мэдээлэл, сонгон шалгаруулалтын захиалгыг Төрийн албаны Зөвлөлийн Яам дахь салбар зөвлөлд 2025 онд 2 удаа хүргүүлж, сул орон тооны зарыг төрийн албаны сайт, дотоод удирдлагын нэгдсэн программ ERP систем болон байгууллагын сайтад байршуулсан. Байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдаас албан тушаалын чиг үүрэг нь хамгийн ойр хамарал бүхий 4 албан хаагчдаар бусад сул орон тоог түр орлон гүйцэтгүүлж байна.	100%		
7		1 дүгээр зүйлийн 1.6 дахь заалт	Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай 1.6. төрийн жинхэнэ албан хаагч жирэмсний болон амаржсаны амралттай байгаа, эсхүл 3 сараас дээш хугацааны сургалтад хамрагдаж сул орон тоо гарснаас бусад тохиолдолд төрийн албаны сул орон тоонд гэрээт ажилтан томилохгүй байх зарчим баримталж, төрийн байгууллагад албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн богино хугацаагаар ажиллуулахаас бусад тохиолдолд гэрээт ажилтан ажиллуулахгүй байх;	Нийслэлийн Биеийн тамир, спортын газарт 2025 онд жирэмсний болон амаржсаны амралт авсан нэг албан хаагчийн сул орон тоонд түр орлон гүйцэтгүүлж байна. Удирдлагын академийн ахлах түшмэлийн сургалтад 1 албан хаагчийг хамруулсан. Сул орон тоонд гэрээт ажилтан авч ажиллуулаагүй болно.	100%		
8				Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын дотоод журмын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт ажлын	100%		

		1.7. төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслах зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусган хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох;	болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг тусган хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох асуудлыг тусгаж нийт албан хаагчдад танилцуулан мөрдлөг болгон ажиллаж байна.			
9	1 дүгээр зүйлийн 1.7 дахь заалт	1.8. төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах;	Нийслэлийн биеийн тамир, спортын газрын даргын 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/28 тушаалаар Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах хүрээнд ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагын Ёс зүйн дэд хороог 3-н хүний бүрэлдэхүүнтэй байгуулж ёс зүйн дүрмийг шинэчлэн батлуулсан. 2025 оны жилийн эцсийн байдлаар ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй бөгөөд иргэд, аж, ахуйн нэгж байгууллагаас албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээлэл ирээгүй байна.	100%		
	5 дугаар зүйлийн 5.1 дэх заалт	5.1.эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн	Биеийн тамир, спортын салбарын мэргэжлийн нэр томьёог оруулах ажлын хүрээнд "Улаанбаатар марафон-2025" олон улсын гүйлтийн удирдамжийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад	100%		

10.		нэр томъёог орчуулах, шинээр үүсгэх, жилдлэх, томилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх;	харицаа, хамтын ажиллагааны хэлтэс, "Хай пей" ХХК-тай хамтран доктор Л.Нямын гаргасан "Монгол-Орос-Англи" хэлний мэргэжлийн нэр томъёоны тайлбар толь"-ийг ашиглан кирилл, монгол бичиг, англи хэлээр хөрвүүлэн https://spot.ub.gov.mn/ сайтад байршуулж 7269 хүнд хүргэсэн байна.			
11.	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 7 дугаар тогтоол	2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 07 дугаар тогтоол Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх;	Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын https://spot.ub.gov.mn/ албан ёсны цахим хуудсанд байршуулсан үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг 2022 оноос хойш кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэн ажиллаж байна. Үүнд: 2022 онд 8, 2023 онд 67, 2024 онд 72, 2025 оны жилийн эцэст 19 мэдээ, мэдээллийг кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлсэн.	100%		
12.	5 дугаар зүйлийн 5.3 дахь заалт	5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших;	Стандарт, хэмнэлзүйн газрын даргын 2022 оны С/13 дугаар тушаалаар батлагдсан "Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага MNS 6395:2022 стандартын дагуу байгууллагын нийтлэг хөтлөгдөх баримт бичгийн хэвлэмэл хуудсыг монгол бичгээр үйлдэх эх загварыг Нийслэлийн Архивын газарт хянуулан батлуулж, хэвлэмэл хуудасны захиалгыг хүргүүлэн 2025 онд 1400 ширхэгийг хэвлүүлж, захирамжлалын болон зохион байгуулалтын баримт бичгийг хос бичгээр хөтлөн явуулж хэвшээд байна.	100%		
13.	5 дугаар зүйлийн 5.4 дэх заалт	5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр,	Байгууллагын албан хаагчдыг монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор сургалтын төлөвлөгөөг гаргасан боловч зохион байгуулалтад шаардагдах зардал төсөвт тусгагдаагүй улмаас албан хаагчдыг бие даан суралцах чиглэл өгч ажиллаж байна.	100%		

		төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх;	Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн үндэсний хэл бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа – I, II” хамрагдаж, чиглүүлэх 2 удаагийн сургалтад давхардсан тоогоор 9 албан хаагч хамрагдсан.			
14.		5 дугаар зүйлийн 5.5 дахь заалт	5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх;	“Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 7 дугаар тогтоолын 5.5 дахь заалтын дагуу байгууллагын гадна хаяг-1, даргын 1102, албан хаагчдын 1116 тоот өрөөний дугаар, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол, кирилл бичгээр хослуулан стандартын дагуу үйлдсэн.	100%	
15.	Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 187 дугаар тогтоол	1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалт	1.1. Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд ирүүлсэн өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэж, салбарын бодлого, шийдвэрт тусгах боломжтой ажил хэрэгч саналыг судлан тусгаж, энэ тухай байгууллагын цахим хуудсанд сар бүр мэдээлж ажиллахыг;	Төрийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэхээр Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын удирдлагууд иргэдийг цайны цагаас бусад бүх цагт хүлээн авч уулзаж, асуудлыг нь тухай бүр шийдвэрлэхээр хуваарь гарган ажиллаж 2025 оны жилийн эцсийн байдлаар 15 иргэнийг хүлээн авч 10 хүсэлтийг шийдвэрлэсэн.	100%	
16.	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн	1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалт	1.1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1, 5.2-т заасны дагуу тэргүүн дэд, дэд, даргатай хориглосон байхыг төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтныг	Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 360 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн зохион байгууллагын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай” А/1059 дүгээр захирамжаар газрын дарга-1, хэлтсийн дарга -2, мэргэжилтэн 13 байхаар баталсан бүтэц орон тоогоор үйл ажиллагаа явуулж байна. Хууль тогтоомж зөрчиж томилсон албан хаагч байхгүй болно.	100%	

203	дугаар тогтоол	ажлаас чөлөөлөх арга хэмжээ авч, тэтгэмжийг зохих журмын дагуу шийдвэрлэх.				
17.	1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалт	2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 203 дугаар тогтоол Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 1.2. жил бүрийн төсвийн төслийн талаарх саналаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлсний үндсэн дээр хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг төлөвлөж, эрх бүхий этгээдэд хүргүүлэх.	Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны батлагдсан төсөв нь 625,062,000. Үүнээс үйл ажиллагааны зардалд 435,587,822, ажилчдын цалин 336,402,895, бусад зардалд 99,184,927 төгрөг зарцуулагдсан.	100%		
18.	1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт	2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 203 дугаар тогтоол Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 1.3. байгууллагын үндсэн чиг үүрэгт шууд хамаарах, үйл ажиллагааны цар хүрээ, онцлог байдал нь танхимаар болон биечлэн хийх зайлшгүй шаардлага үүсдэгээс бусад тохиолдолд сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулах.	Хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд: Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академи, Биеийн тамир, спортын Улсын хороо, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Хүний нөөцийн хөгжлийн төв, Нийслэлийн Архивын газар зэрэг дээд байгууллагаас зохион байгуулсан танхим-23, цахим-19 нийт 42 удаагийн сургалтад давхардсан тоогоор 100 гаруй албан хаагчдыг хамруулсан байна. Үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд: Спортын төрлүүдийг хөгжүүлж, багш, дасгалжуулагчдын ур чадварыг дээшлүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх, туршлага солилцох зорилгоор сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш, арга зүйч, ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын багш болон биеийн тамир, спортын хамтлагийн арга зүйч, шүүгчид, сайн дурын ажилтнуудад зориулсан 8 төрлийн сургалт зохион байгуулж 225	100%		

			байгууллагын 1430 багш, дасгалжуулагч, арга зүйчид, оюутнууд хамрагдаж улсын төсвөөс 6,445,000 (зургаан сая дөрвөн зуун дөчин таван мянган) төгрөгийг зарцуулж хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан.			
19.	Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай 2018 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 138 дугаар тогтоол	2 дугаар зүйл	Төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн интернэт сүлжээг олон нийтийн сүлжээ, онлайн тоглоомын болон видео сан бүхий сайтуудад нэвтрэхгүй болгож албан бичиг, баримтыг олон нийтийн сүлжээгээр дамжуулах болон тусгай программ хангамж ашиглан олон нийтийн сүлжээнд хандахыг хориглох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг.	Төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн интернэт сүлжээг олон нийтийн сүлжээ, онлайн тоглоомын болон видео сан бүхий сайтуудад нэвтрэхгүй болгож албан бичиг, баримтыг олон нийтийн сүлжээгээр дамжуулах болон тусгай программ хангамж ашиглан олон нийтийн сүлжээнд хандахыг хориглох чиглэлээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Дэд бүтэц, техникийн хяналтын хэлтэс болон холбогдох дээд байгууллагаас зохион байгуулалтын арга хэмжээ авсны дагуу facebook, youtube, photoshop зэргийг ашиглах хязгаарлалт тогтоосон.	100%	
20.	Журам батлах тухай /нээлттэй мэдээлэл/ 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 201 дүгээр тогтоол	2 дугаар зүйл	2.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг.	Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ын дагуу байгууллагын албан ёсны цахим хуудсаар байгууллагын үйл ажиллагааны мэдээллийг ил тод нээлттэй мэдээлж хэвшсэн бөгөөд 2025 онд зохион байгуулсан биеийн тамир, спортын 50-н ажил, үйлчилгээний 150 мэдээг sport.ub.gov.tl цахим хуудсанд байршуулж 33,869 хүнд, "Нийслэлийн Биеийн тамир, спортын газар" пэйж хуудсанд 748 нийтлэл байршуулж, 2,845,974 удаа хүргэж, 54,558 удаа шэйр хийж, 160 рийлсгийг 2,564,156 удаа үзэж, 85 зүйлийн 6875 зураг байршуулж 4,874,195 удаа үзсэн байна. Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа, цаг үеийн шаардлагатай мэдээ, мэдээллийг 1265 удаа	100%	

			хувь хүн, байгууллагатай цахим шуудангаар мэдээ, мэдээлэл солилцсон.		
21.	Журам шинэчлэн батлах тухай 2017 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 57 дугаар тогтоол	1 дүгээр зүйл	1."Байгууллага хоорондын гэрээ байгуулах журам"-г хавсралт ёсоор батлах тухай;	100%	
22.	2024 оныг "Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил" болгон зарлах тухай 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 481 дүгээр тогтоол	4 дүгээр зүйл	4.Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын төслийг боловсруулах, холбогдох тооцоо, судалгаа хийх, санал өгөх чиглэлээр хамтран ажиллахыг;	100%	
23.	Журам батлах тухай 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 77 дугаар тогтоол	3 дугаар зүйл	3."Суурь болон төрөлжсөн мэдээллийн сант цахим хэлбэрээр шинээр үүсгэх, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгүүлэх журам"-г баталж үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг ханган ажиллахыг;	100%	
Хэсгийн дундаж 100 хувь					
4.МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС					
1.	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдааны 47	3 дугаар зүйл	3.Гэрээний хэрэгжилтийн мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасан тохиолдолд холбогдох улсын байцаагчийн дүгнэлт	100%	
			Нийслэлийн Засаг даргын 2022 оны "Эрх шилжүүлэх тухай" А/1272 дугаар захирамжийн хүрээнд Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/48 дугаар тушаалаар томилогдсон Тонот төхөөрөмж хүлээн авах комисс нь захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан БГД-		

	дугаар тэмдэглэлээс		гаргуулан нотлох баримт, мэдээллийн хамт худалдан авах ажиллагааны улсын байцаагчид тухай бүр нь хүргүүлж байхыг захиалагч буюу төсвийн холбогдох захирагч нарт;	ХААА/НОНХС-22-14 дугаартай гэрээний дагуу "Электрон техник" ХХК-иас нийлүүлж байгаа тоног төхөөрөмжийг гэрээний хавсралт, ерөнхий болон тусгай нөхцөлд тусгагдсан техникийн тодорхойлолтын шаардлагыг хангасан байдал, барааны чанар, тээвэрлэлт, хадгалалт болон тоног төхөөрөмжийн холбогдох баримтуудтай газар дээр нь танилцан хяналт тавьж ажилласнаар гүйцэтгэгч нь тоног төхөөрөмжийг Баянгол дүүргийн Биеийн тамир, спортын хороонд бүрэн нийлүүлж, угсарч суурилуулан үйл ажиллагаанд оруулж гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн. "Электрон техник" ХХК-аас нийлүүлсэн тоног төхөөрөмжүүдийн баталгааны нэг жилийн хугацаанд эвдрэл гэмтэлгүй хэвийн ажилласан тул ажлын хэсгээс гаргасан шийдвэрийн дагуу баталгаат хугацаанд байршуулсан 1,474,850 төгрөг (нэг сая дөрвөн зуун далан дөрвөн мянга найман зуун тавин)-ийг чөлөөлөх ажлыг бүрэн дуусгасан.			
2.	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдааны 13 дугаар тэмдэглэлээс	1 дүгээр зүйл	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаат шуурхай зохион байгуулах, эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийн талгаар мэдээллийг олон нийтэд сурталчлан таниулах арга хэмжээг;	Улсын төсвөөр баригдаж байгаа Багахангай, Баянзүрх дүүргийн спорт цогцолбор, Сонгинохайрхан дүүргийн өвлийн спортын ордон, усан спортын төвийн барилгын явцын биелэлтийг холбогдох байгууллагуудаас цаг тухай бүр авч бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан заалт тус бүрээр биелэлтийг гаргаж байгууллагын удирдлага болон дээд шатны байгууллагуудыг мэдээллээр ханган ажиллаж байна. Үүнд: Сонгинохайрхан дүүргийн 34-р хороонд баригдаж байгаа усан спортын төвийн барилга баригдаж дууссан бөгөөд улсын комисст өгөх ажил хүлээгдэж байна. Баянзүрх дүүргийн спорт цогцолбор 85 хувьтай, Багахангай дүүргийн спорт цогцолбор 97 хувьтай, Сонгинохайрхан дүүргийн 20-р хороонд баригдаж байгаа өвлийн ордон 50 хувьтай, Хан-Уул дүүргийн Оюуны спортын ордон 90 хувьтай баригдаж байна.	100%		

3.	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны 15 дугаар тэмдэглэлээс	1 дүгээр зүйл	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд байнга ил тод, нээлттэй байлгахаар заасан мэдээллийг “Нээлттэй мэдээллийн систем (shien.gov.mn)-д байршуулах ажлыг хариуцсан салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, мэдээллийг тухай бүр шинэчилж ажиллахыг төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой байгууллагуудын удирдлага, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангаж зайлшгүй байрших 5 чиглэл (Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 18; Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 7; Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 29; Үзүүлж байгаа үйлчилгээний талаар дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байдлын 6; Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдлын 27)-ийн 86-н үзүүлэлтээс манай байгууллагад хамааралтай 72 үзүүлэлтийн мэдээ, мэдээллийг байгууллагын sport.cb.gov.mn цахим хуудсанд байршуулж, нээлттэй мэдээллийн систем (shien.gov.mn)-д мэдээллийг цахим хуудсандаа байршуулсныг баталгаажуулах зураг, линкийг оруулан 2025 оны жилийн эцсийн тайланг 12 дугаар сарын 03-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт албан тоотоор хүргүүлсэн.	100%		
4.	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн хуралдааны 18 дугаар тэмдэглэлээс	2 дугаар зүйл	Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2027)-г салбар, харьяа нутаг дэвсгэрийн хүрээнд зохион байгуулах, зардлыг шийдвэрлэж ажиллахыг;	Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар: Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжиж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөний хүрээнд иргэдэд эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэхээр 13 арга хэмжээ бүхий бэлтгэл ажлын төлөвлөгөө баталж жилийн эцсийн байдлаар биелэлт 100 хувьтай байна. Нийслэл, дүүргийн хэмжээнд 2025 онд нийтийн биеийн тамирын 270 арга хэмжээ зохион байгуулж 6600 байгууллагын 1,151,456 иргэнийг хамруулж нийслэлийн төсвөөс 2,144,338,900 төгрөг, улсын төсвөөс 244,594,100 төгрөг, дэмжигч байгууллагаас 83,360,000 төгрөгийг зарцуулсан байна. Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас 2025 оны жилийн эцсийн байдлаар нийтийг хамарсан 13 үйл ажиллагаа зохион байгуулж (ерөнхий боловсролын сургуулийн багш нарын сургалт, хөгжөөн дэмжигчдийн арга хэмжээ, цэцэрлэгийн уран хөдөлгөөнт гимнастик, хүн амын	100%		

		бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил, "Улаанбаатар марафон-2025", "Алхацгаа гүйцгээ" хөдөлгөөн, олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн арга хэмжээ) 303 байгууллага, 487,144 иргэнийг хамруулсан.		
--	--	--	--	--

Хэсгийн дундаж 100 хувь

5.МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН АЛБАН ДААЛГАВАР

1.	2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 01 дүгээр албан даалгавар	1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалт	1.1.Иргэндээ ээлтэй хуулийн засаглалыг бэхжүүлэх: Төрийн бүх шатны байгууллагын албан хаагчид шударга ёс, хууль дээдлэх зарчим баримтлан, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, улс төрөөс ангид, мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ажиллах;	Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын Ёс зүйн дэд хороог 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр хамт олны хурлаар хэлэлцэн санал хурааж 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан байгууллагын даргын 2025 оны А/13 тушаалаар батлуулж, 2025 оны Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөөг байгууллагын даргаар батлуулан хагас, бүтэн жилээр хэрэгжилтийг тайлагнан ажилласан. 2025 оны жилийн эцсийн байдлаар Ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй бөгөөд иргэд, аж, ахуйн нэгж байгууллагаас албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээлэл ирээгүй байна.	100%		
2.	2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 01 дүгээр албан даалгавар	1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалт	1.2.Авлигын хяналтыг сайжруулах: Төрийн албыг хувийн ашиг сонирхлын хэрэгсэл болгох гэсэн оролдлогыг тухай бүр нь таслан зогсоож, авлига, хээл хахууль, хүнд суртал, шударга бус байдластай шат шатандаа тууштай тэмцэх;	Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийн эхний хагас жилийн тайланг 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 02/158 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хургуулсан. Жилийн эцсийн тайланг 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдөр буюу хугацаанд нь дээд газарт хургуулэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Авлигатай тэмцэх газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ХАСХОМ гаргах албан хаагчдад зориулан зохион байгуулсан 4 удаагийн сургалтад давхардсан тоогоор 69 албан хаагчийг хамруулан ажилласан. Мөн ХАСХОМ-ийг мэдүүлэх нийслэл, дүүргийн биеийн тамир спортын газар, хороодын 51 албан хаагчид хуулийн хугацаанд мэдүүлгийг гарган баталгаажуулж, мэдээллийг Биеийн тамир, спортын улсын хороонд хургуулж ажилласан.	100%		

			1.3.Иргэдээ төрийн харууллагыг өндөржүүлэх: "Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төв"-д иргэдээс өргөдөл, шуурхай шалгаж, шийдвэрлэн гаргасан албан тушаалтанд тухай бүр харууллага тооцож ажиллах;	2025 онд авлига ашиг сонирхлын зөрчил гаргасан албан хаагч байхгүй болно.			
3.	2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 01 дүгээр албан даалгавар	1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт	Төрийн үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэхээр Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын удирдлагууд иргэдийг цайны цагаас бусад бүх цагт хүлээн авч уулзаж, асуудлыг нь тухай бүр шийдвэрлэхээр хуваарь гарган ажиллаж 2025 оны жилийн эцсийн байдлаар 15 иргэнийг хүлээн авч 10 хүсэлтийг шийдвэрлэсэн бол иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх хугацааг 9, шийдвэрлэлтийн дундаж 2 хоног 12 цаг 49 минут байна.	100%			
4.	2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 01 дүгээр албан даалгавар	1 дүгээр зүйлийн 1.4 дэх заалт	Төрийн албаны соёл, дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалтын талаар Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэгт тусган хэрэгжилтийг ханган ажиллаж, цаг ашиглалтыг сайжруулах зорилгоор "АНАНД ТУЛГА" ХХК-тай хамтран ажиллаж царайгаар таних цагийн бүртгэлийн төхөөрөмжийг суурилуулан Нийслэлийн Нутгийн захираганы байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системээр хянан ажиллаж байна.	100%			
5.	2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 01 дүгээр албан даалгавар	1 дүгээр зүйлийн 1.5 дахь заалт	Удирдлагын академийн ахлах түшмэлийн багц сургалтад Спорт, нийтийн биеийн тамирын ахлах мэргэжилтэн Э.Мөнх-Эрдэнэ нь 2024 оны 10 дугаар сараас эхлэн суралцаж, №А5179 дугаартай сертификат эзэмшиж, төрийн мэргэшсэн албан хаагч боллоо.	100%			

Хэсгийн дундаж 100 хувь

Хэсгийн дундаж 100 хувь

Нийслэлийн Биеийн тамир, спортын газар нь 2025 онд 26 хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 40 заалтыг хяналтад авч хэрэгжилтийн дундаж 100 хувьтай үргэлжилж байгааг Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 6 дугаар зүйлийн 6.1-т заасан аргачлалын дагуу "бүрэн хэрэгжсэн" буюу 99.75 хувьтай гэж үнэллээ.

1. Биеийн тамир, спортын тухай хуулийн 12, 13, 23 дугаар заалтын дундаж 95.7 хувьтай,
2. Ерөнхийлөгчийн 4 зарлиг(53, 27, 144, 43)-ын 4 заалтын дундаж 100 хувьтай,
3. Засгийн газрын 12 тогтоол(183, 204, 163, 258, 7, 187, 203, 138, 201, 57, 481, 77)-ын 23 заалтын дундаж 100 хувьтай,
4. Засгийн газрын 04 хуралдааны тэмдэглэл(47, 13, 15, 18)-ийн 4 заалтын дундаж 100 хувьтай,
5. Засгийн газрын 01 дүгээр албан даалгаврын 5 заалтын дундаж 100 хувьтай.

ТАНИЛЦСАН:

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

М.ЦОГЗОЛМАА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ЭРХ ЗҮЙ, ТОГТООЛ ШИЙДВЭР
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

МУАЖИДЭР Б.ХҮСЛЭНБАЯР